



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн гишүүн, нарийн
бичгийн даргыг чөлөөлж, нарийн бичгийн
даргыг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.1.10 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4, 2.9, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны Б/28 дугаар тушаал, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2020 оны Б/256, Б/260 дугаар тушаал гарсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Дэд дарга Д.Түвшинтөр, Хяналт шалгалтын газрын дарга Н.Баянмөнх нарыг салбар зөвлөлийн гишүүнээс, Захиргааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Алтангэрэлийг салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаас тус тус чөлөөлсүгэй.

2. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2020 оны Б/320 дугаар тушаал гарсантай холбогдуулан Захиргааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн В.Шоовдоргыг тус газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсугай.

3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга В.Шоовдорт үүрэг болгосугай.

4. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

20000869



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Салбар зөвлөлийн 2021 оны үйл
ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1.5, 4.2.2, Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр мэдээлж, хагас бүтэн жилээр тайланг нэгтгэн танилцуулахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн /В.Шоовдор/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

000000027